

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201.. оныдугаар
сарын ний өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуулийн дараах зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“5.3.Энэ хуулийн 5.2-т заасны дагуу тодорхойлсон хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хот, тосгонд хүнсний асуудал хариуцсан төрийн байгууллага, сум, дүүрэгт хүнсний асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.”

2/8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“8.6.Хүнсний салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгоно. Хүнсний салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“10.4.Энэ хуулийн 10.1.8-д заасан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт зэрэглэл тогтоох, нийтэд мэдээлэх журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

4/10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“10.1.8.хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт зэрэглэл тогтоолгож, нийтэд ил тод мэдээлэх.”

5/13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

“13.1.5.хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт энэ хуулийн 10.4-т заасан журмын дагуу тогтоосон зэрэглэл”

6/14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

“14.1.5.энэ хуулийн 10.1.1 болон 10.1.5-д заасан сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.”

2 дугаар зүйл.Хүнсний тухай хуулийн 3.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүн” гэсний дараа “хоол” гэж, 10.1.1 дэх заалтын “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч” гэсний дараа “тухайн салбарын ерөнхий чиг баримжаа олгох сургалтад хамрагдаж” гэж, 10.1.5 дахь заалтын “хүний нөөцтэй байх” гэсний дараа “мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчгийн “Хүнсний хангамжийг тодорхойлох” гэснийг “Хүнсний хангамж” гэж, 10.1.5 дахь заалтын “болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “үйлдвэрлэл болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 16.1 дэх хэсгийн “улсын бүртгэлд бүртгэнэ” гэснийг “бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтөлнө” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 20... оны ... сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.